



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 10/04

Хөхбүрд

Сумын сонгуулийн хороо байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дүгээр зүйлийн 48.1, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 17 дугаар зүйл 17.2 дах заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын аравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулах сумын сонгуулийн хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: М.Жавзансүрэн (сумын Засаг даргын Тамгын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Болортуяа (Соёлын төвийн архив, бичиг хэрэг)

Гишүүд: Ж.Ёндонпил (Мал эмнэлгийн тасгийн дарга)


Л.Гүндцамба (Хөдөө аж ахуйн тасгийн дарга)

Ж.Амарцэцэг (Сургуулийн дотуур байрын багш)

2. Нөхөн сонгуулийг хууль тогтоомжид заасан цаг хугацаанд удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын сонгуулийн хороо (М.Жавзансүрэн)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Удирдлага зохион байгуулалтын хороо (Х.Эрдэнэбат)-д даалгасугай.

ДАРГА  Б.ОТГОНБАЯР



648801057